

ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ЗАГВАРААР БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

¹Ганчимэг Ч, ²Алгирмаа Л, ²Туяа Б, ²Баясгаланмөнх Б, ³Болорсайхан О,
¹АШУҮИС-ийн АУС, ЭЗЛТ
²АШУҮИС-ийн Дархан-Уул.АУС,
³АШУҮИС-ийн ЗХШҮГ

Түлхүүр үг: Чадамжид суурилсан сургалт, хөтөлбөр, чадамжийн нэгж, чадамжийн элемент

Удиртгал:

Орчин үед техник технологийн дэвшил, инноваци, мэдээллийн эрин үе, чанартай амьдралд тэмүүлэх хүний хүсэл, хэрэгцээ бүхэн нийлээд шинэ зууны дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага болжээ. Ийм үед дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн чиг хандлагыг баримтлах болсон бөгөөд манай улс ч ялгаагүй тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд МБС-ыг Чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд шилжүүлэх, орчин үеийн дэлхий нийтийн МБС-ын загварт нийцүүлэн хөгжүүлэх тухай Мэргэжлийн Боловсролын тухай хуулинд заасан байдаг.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалт нь эрэлтээр удирдуулсан, салбар дундын зохицуулалт бүхий, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан тогтолцоонд шилжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Өөрөөр хэлбэл МБС-ын шинэ загварыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн салбарын төлөөллийг идэвхтэй оролцуулах, тэдний нөлөөллийг буй болгох замаар эрэлтээр удирдуулсан боловсролын удирдлагын чиг хандлагыг буй болгон хөгжүүлэх талаар тусгажээ.

Орчин үеийн МБС-ын үр нөлөөг төгсөгчдийн хэдэн хувь нь ажлын байртай болсон гэхээс илүү хэд нь өндөр шаардлагатай шинэ технологитой ажлын байранд орж чадаж байна гэдэг шалгуур үзүүлэлт гарч ирсэн.. Олон улсад МБС-ын байгууллагууд эрэлтэд хариу барихаас илүү эрэлтийг угтсан түвшинд, эрэлтийг хайж олох, эрэлтийг буй болгох түвшинд өндөр түвшний өрсөлдөөнд чиглэсэн сургууль, үйлдвэрлэл хамтарсан бүлэглэл, түншлэлийг буй болгох арга замыг эрэлхийлэх болжээ.

Нэг үе бид суралцагсдад илүү ихийг мэдүүлэхийг зорьж, аливаа зүйлийг хийж чадах нь чухал хэмээн үздэг байсан ойлголт маань мэдлэгийн засаглал чиглэлтэй мэдлэгжсэн ур чадварын талаар яригдах болжээ.

Чадамжинд суурилсан сургалт нь уламжлалт сургалтаас юугаараа ялгаатай юм бэ? гэвэл сургууль төвтэй, танхимийн сургалтаас илүү үйлдвэрлэлдээрх сургалт давамгайлдаг, хөтөлбөр, стандартыг сургууль, багш үйлдвэрлэл, аж ахуйн нэгж хамтран боловсруулаад, үйлдвэрлэл нь

баталгаажуулдаг, сургалт нь уян хатан, суралцагч төвтэй, багш нь суралцагчийн сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын дутуу орон зайг тодорхойлох, суралцагчийн гаргаж буй амжилт, ахиц, ажлын гүйцэтгэлийг хэмжих, ахиц дэвшихэд нь туслах, ур чадвар эзэмшүүлэхэд чиглүүлдэг бөгөөд сургалтын үнэлгээний тусгайлсан удирдлагатай сургалтын тогтолцоо юм.

Манай улсад НХХЯ-ны баталсан Монгол улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт YAMAT-08 ангиллаар лабораторийн техникч мэргэжилтний индекс нь HO-3212-17, техникийн боловсролын V-YI түвшинд байна хэмээн заасан байдаг.

2018 оноос АШУҮИС-ийн лабораторийн техникчийн багш нарын баг лабораторийн техникч мэргэжилтэн бэлтгэх ЧССХ-ийг Монгол Улсын Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын А/197 тоот Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар боловсруулах тухай тушаал, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 45-р дугаар тогтоолоор батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын ерөнхий шаардлага MNS6541:2015 стандартыг үндэслэн шинэчилэн боловсруулсан.

Орчин үед анагаах ухааны сургалт, мэргэжлийн боловсролын чадамжид суурилсан сургалт аль аль нь мэдлэгийг чадварт хөрвүүлж ашиглаж чаддаг байх нь мэдлэгтэй байхаас хавьгүй чухал, бүтээмжтэй ажиллаж чаддаг байх нь ур чадвартай байхаас хавьгүй чухал, бусдад ээлтэй байх нь зөв хандлагатай байхаас хавьгүй чухал гэсэн үндсэн зарчмыг баримтлах болсон байна.

Лабораторийн техникч мэргэжилтэн бэлтгэх ЧССХ-ийг Анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн загварт тохируулан, суралцагчийг насанд хүрэгчдийн боловсролын тогтолцоогоор тасралтгүй сургах, хүн амд лабораторийн шинжилгээний тусламж үзүүлэх, лабораторийн техникч мэргэжилтний мэргэжлийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийн ёс зүй, хандлагыг төлөвшүүлэхэд чиглүүлэн боловсруулсан.

Мэргэжил бол чадамжуудаас бүрддэг. Чадамжийн стандартын түлхүүр хэсэг нь чадамжийн нэгжүүд бөгөөд өөрөөр хэлбэл ажил мэргэжлийг тодорхойлдог түлхүүр үзүүлэлт, даалгаварууд нь юм. Чадамжийн нэгжийн нэр нь

чадамжийн үр дүн болон гарах тодорхойлолт болно.

Материал арга зүй, үр дүн:

Лабораторийн техникч мэргэжилтэний чадамжийн стандартын мэргэшүүлэх хүрээний чадамжийн нэгжийг 1-р хүснэгтээр харууллаа.

1-р хүснэгт

Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код	Чадамжийн элементийн тоо
Лаборатори техникийн үндэс	HO3212-17 2117	4
Лабораторийн суурь багаж	HO3212-17 2118	4
Лабораторийн биоаюулгүй ажиллагаа	HO3212-17 2119	6
Мэргэжлийн ёс зүй	HO3212-17 2120	3
Ариутгал, халдваргүйтгэлийн техник	HO3212-17 2121	6
Лабораторийн хэрэглээний нэр томёо, тооцоолол	HO3212-17 2122	4
Биохими	HO3212-17 2223	4
Молекул, эсийн биологи	HO3212-17 2224	4
Удам зүй	HO3212-17 2225	4
Бичил амь судлал	HO3212-17 2226	4
Сувилахуйн ур чадвар	HO3212-17 2227	4
Дархлаа судлалын шинжилгээний арга техник	HO3212-17 2228	6
Лабораторийн шинжилгээний чанарын хяналт	HO3212-17 3129	6
Клиник химийн шинжилгээний арга техник-1	HO3212-17 3130	4
Гистологи, Цитологи	HO3212-17 3131	4
Гематологийн шинжилгээний арга техник-1	HO3212-17 3132	6
Гематологийн шинжилгээний арга техник-2	HO3212-17 3133	6
Эмнэлзүйн Биохимийн шинжилгээний арга техник-1	HO3212-17 3134	6
Эмнэлзүйн Биохимийн шинжилгээний арга техник-2	HO3212-17 3235	6
Иммуногематологийн шинжилгээний арга техник	HO3212-17 3236	5
Микробиологийн шинжилгээний арга техник-1	HO3212-17 3237	6
Микробиологийн шинжилгээний арга техник-2	HO3212-17 3238	6
Молекулбиологийн шинжилгээний арга техник	HO3212-17 3239	4
Клиник химийн шинжилгээний арга техник-2	HO3212-17 3240	4

ЧСС-ын сургалтын тогтолцооны гол шинж чанар нь чадамжийг нарийн тодорхойлсон байдагт оршино.

Лабораторийн техникч мэргэжилтний чадамжийн стандартын зайлшгүй эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох зорилгоор “Лабораторийн техникч мэргэжилтэний “ЦОГЦ ЧАДАМЖ” боловсруулсан.

ЧССХ болон “Лабораторийн техникч мэргэжилтний ЦОГЦ ЧАДАМЖ”-ийг боловсруулахдаа Австрали улсын Холмесглен сургуулийн Лабораторийн техникч мэргэжилтэн бэлтгэдэг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг харьцуулахаас гадна лабораторийн техникч мэргэжилтний гүйцэтгэх үүрэг, мэргэжлийн тодорхойлолт, ажлын байрны тодорхойлолт, ажилбарын жагсаалтын талаар ажил олгогч байгууллагуудын төлөөллүүдийг урин, уулзалт зохион байгуулан санал авч боловсруулсан бөгөөд ижил төстэй сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг Дархан-уул, Дорноговь, Говь-Алтай аймгийн АШУУИС-ийн салбар сургуулиудийн Лабораторийн техникчийн ангид мэргэжлийн

хичээл заадаг багш нартай сургалт семинар зохион байгуулан

Лабораторийн техникч мэргэжилтэний ЧСС-ийн хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэжүүлэх хичээлүүд нь чадамжийн 24 нэгж, 111 чадамжийн элементтэй. Чадамжийн элемент нь чадамжийн нэгжийн дагуу гүйцэтгэх ёстой ажлын гол хэсгүүд буюу ажилбар юм. Өөрөөр хэлбэл ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хэрэгцээт үйлдлүүд юм. Мөн чадамжийн элемент болгоныг ажилтан ажлаа стандартын дагуу гүйцэтгэхийн тулд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохоос гадна ажилтан ажлын байранд ямар ажлыг хийх ёстой, гүйцэтгэлийг хэр сайн хийж гүйцэтгэх, стандартын дагуу ямар орчинд хийж гүйцэтгэх вэ? гэсэн чадамжийн элементийн шалгуур үзүүлэлтийг боловсруулдаг. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь чадамжийн элементүүдийг стандартын шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг үнэлэхэд чухал ач холбогдолтой үнэлгээний суурь шалгуур үзүүлэлт болдог.

ЧССХ-ийг боловсруулахад чадамжийн талаарх ойлголтыг анхааран авч үзэх шаардлагатай.

Чадамж гэдэг нь хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавигдах мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд эзэмшсэн байвал зохих чадвар бөгөөд аливаа ажлыг бие даан хийж гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагдахуйц, хэмжигдэхүйц мэдлэг, ур чадвар болон зан байдлын хандлагын иж бүрэн цогц ойлголт юм. Өөрөөр хэлбэл чадамж гэдэг нь тусгай нөхцөлийн доор тодорхойлсон стандартын дагуу ажил гүйцэтгэх ур чадварыг хэлнэ.

Ур чадвар гэдэг нь чадамжийн тодорхой түвшний нэг болон хэд хэдэн ажилбарыг шаардлагатай багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан гүйцэтгэх бие бялдарын болон сэтгэл зүйн чадавхи бөгөөд ажилтны ажилдаа хандах хандлага, мэргэжлийн мэдлэг, ур чадварын цогц төлөвшил юм.

Чадамжийн нэгжийг тодорхойлох нь үнэлгээний удирдамжийг боловсруулахад чухал ач холбогдолтой. Үнэлгээ сургалтын үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа, ямар үр дүнд хүрсэн талаар мэдэхийн тулд зорилго бүхий үйл ажиллагаанаас мэдээллийг цуглуулж зохион байгуулах үйл явц юм. Үнэлгээний ажилтан үнэлгээний төлөвлөгөө боловсруулахад дараах асуултанд хариулах шаардлагатай байдаг. Үүнд: Үйл ажиллагааг гүйцэтгэхэд ямар чадварууд хэрэгтэй вэ?, ур чадварын ямар түвшин хэрэгтэй вэ?, ур чадвартай гэдгийг батлахад ямар нотолгоо хэрэгтэй вэ?, үйл ажиллагааг гүйцэтгэхэд ямар мэдлэг, ур чадвар шаардлагатай вэ?, нотолгоог хаана цуглуулах вэ? зэрэг асуултанд хариулах шаардлагатай болдог.

Суралцагчийн үнэлгээг үнэлгээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулана. Үнэлгээний ажилтан үнэлгээний зорилгоо тодорхойлон, төлөвлөгөө гаргана, үнэлгээний үйл ажиллагааны тоймоо гаргана. Үнэлгээний шалгуур үзүүлэлт нь тухайн салбарын хүрээнд улс орон даяар хүлээн зөвшөөрөгдсөн батлагдсан чадамжийн стандарт, эсвэл тодорхой хувийн хэвшлийн байгууллагын стандартын томъёолсон чадамжууд байж болно.

Дүгнэлт:

1. Лабораторийн техникч мэргэжилтний үндэсний хэмжээний чадамжийн стандартыг АШУҮИС-ийн харъяа УБ хотын, Дархан-Уул, Говь-Алтай, Дорноговь аймгийн салбар сургуулиуд хамтран боловсруулж батлуулсан ижил хөтөлбөртэй байх.

2. Лабораторийн техникч мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиуд чадамжид суурилсан хөтөлбөрийн загвараар боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж нэгдсэн хөтөлбөр, нэг стандартын дагуу сургалтын үйл ажиллагааг явуулах хэрэгтэй байна.

Ашигласан материал:

1. Мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэжлийн түвшний тогтолцооны нэр томъёоны тайлбар толь. МБС-ын төсөл, УБ. 2011 он
2. Анагаах ухааны боловсрол судлал. Эрдэм шинжилгээний бүтээл. УБ.2010 он
3. Б.Галбадрах. “Чадамжид суурилсан сургалт ба үнэлгээ” УБ. 2013 он.
4. С.Болор-Эрдэнэ “Чадамжид суурилсан сургалтын гарын авлага”, УБ. 2013 он,
5. Ц.Лхагвасүрэн нар. Анагаах ухааны боловсрол судлал. УБ. 2007 он